Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын зөвлөлийг Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/33 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд нийт 10 ажил хийхээр төлөвлөсөн байна. Үүнээс 4 ажил нь байгууллагын санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой байна. Дотоод хяналтын зөвлөлийн ажлыг тайланд төлөвлөгөөнд тусгагдсан 2 ажилд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ. Санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулга болон Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.4, 54.5 дахь заалт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж ирүүлээгүй байсныг аудитын хугацаанд бэлтгүүлсэн.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,261.4 мянган төгрөгөөр буюу 7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	7,559.8	7,572.4	12.6
Бараа материал	127,605.8	155,634.1	28,028.4
Биет хөрөнгө	680,515.3	619,375.7	-61,139.6
Биет бус хөрөнгө	43,294.3	95,973.8	52,679.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>916,854.0</b>	<b>981,115.4</b>	<b>64,261.4</b>
Хуримтлагдсан үр дүн	-4,461,155.9	-4,396,894.5	64,261.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>916,854.0</b>	<b>981,115.4</b>	<b>64,261.4</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайланд онд үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлд 12.6 мянган төгрөгийн авлагатай байна.
- Бараа материалын дансанд 2013 онд ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан үхрийн төл болох 44 бярууг иргэдэд түрээслүүлснийг тайлант онд 35,200.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.
- Төсвийн хөрөнгөөр 36,179.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.
- Орон нутгийн хөгжлийн сан болон Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 73,473.4 мянган төгрөгийн хөрөнгийн орлого авч бүртгэсэн байна.

Хуримтлагдсан үр дүн 64,261.4 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 601,768.0 мянган төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 131,848.9 мянган төгрөгөөр бууруулж, 469,919.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 190,945.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 660,864.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 615,061.0 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа ба 45,803.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

#### Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70106</b>	<b>Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>447,472.0</b>	<b>419,496.7</b>	<b>27,975.3</b>	<b>93.7</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	286,717.0	265,234.3	21,482.7	92.5
80106	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	42,332.8	42,332.8	0.0	100.0
80112	Нийтлэг үйлчилгээ	34,270.3	34,217.7	52.6	99.8
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,000.0	2,000.0	0.0	100.0
82801	Баяр наадмын зардал	8,000.0	8,000.0	0.0	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	27,901.8	27,901.8	0.0	100.0
80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	21,710.1	21,710.1	0.0	100.0
81518	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх	7,540.0	7,540.0	0.0	100.0
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	8,560.0	6,440.0	57.1
82501	Мал эмнэлгийн үйлчилгээ	1,000.0	1,000.0	0.0	100.0
82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	1,000.0	1,000.0	0.0	100.0
<b>70503</b>	<b>Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт</b>	<b>185,242.8</b>	<b>167,653.0</b>	<b>17,589.8</b>	<b>90.5</b>
80918	Бусад	185,242.8	167,653.0	17,589.8	90.5
<b>71413</b>	<b>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх</b>	<b>28,149.6</b>	<b>27,911.3</b>	<b>238.3</b>	<b>99.2</b>
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	28,149.6	27,911.3	238.3	99.2
	<b>НИЙТ</b>	<b>660,864.40</b>	<b>615,061.0</b>	<b>45,803.4</b>	<b>93.1</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах орлогууд орсон байна. Үүнд:

- Хөвсгөл ус суваг ХХК-аас төрөөс хариуцах цэвэр бохир усны үлдэгдэл төлбөр 3,696.0 мянган төгрөг
- Хөдөө аж ахуйн мал тооллогын зардал 2,733.2 мянган төгрөг
- Биеийн тамир спортын газраас нийтийн биеийн тамирын үйл ажиллагааны зардалд 1,500.0 мянган төгрөг
- Аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардалд 300.0 мянган төгрөг
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 130.5 мянган төгрөг
- Цахим тендерийн орлого 350.0 мянган төгрөг

Нэмэлт санхүүжилтийн данснаас зохих журмын дагуу эрхийг нээлгэж, зарцуулалтыг хийсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 2/78 албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 560,199.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,203.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 8,963.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томиллолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн

байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төсвөөс тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамаарахгүй 36,552.5 мянган төгрөгийн дараах зардлуудыг санхүүжүүлжээ. Үүнд:

- Сургуулийн халуун усны засварт 6,000.0 мянган төгрөг
- Эрүүл мэндийн төвийн зуух шинэчлэх, суурилуулах зардалд 9,950.0 мянган төгрөг
- Багийн эмч нарт эмийн фонд нэмэгдүүлэх арга хэмжээний зардал 3,600.0 мянган төгрөг
- ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх зардалд 7,052.5 мянган төгрөг
- Хүүхдийн цэцэрлэгийн нам даралтын зуух солих, суурилуулах зардалд 9,950.0 мянган төгрөг

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 4.1.27."орон нутгийн төсөв" гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг; 6.6.6.тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

##### **Шийдвэрлэлт:**

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд 100 хувьтай байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажиллах албан шаардлага, төсвийн эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх болон шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 3 зөвлөмжийг өгсөн байна. Тайлант онд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах болон төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажилласан ба дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,000.0	1	2,000.0	100.0
Зөвлөмж	3	380.0	2	380.0	67.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>2,380.0</b>	<b>3</b>	<b>2,380.0</b>	<b>75.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 182,000.0 мянган төгрөгийн Хөдөө аж ахуйн тракторын багцыг Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлэх аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын тушаал гарсан боловч хөрөнгийг биетээр хүлээж аваагүй тул бүртгэлд тусгаагүй байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайланд 45,803.4 мянган төгрөгийн төсвийн тохируулга хийгээгүй байсныг аудитын хугацаанд залруулсан.

Аудитаар 42,268.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 3,580.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36,552.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,135.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүллээ.

#### 5.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 3,580.1 мянган төгрөгийн дараах зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

- Нохой устгалын ажил гүйцэтгэх гэрээнд сумны мөнгө 750.0 мянган төгрөгийг бүрэн хариуцахаар заасан боловч сумны мөнгийг давхардуулан олгосон байна.
- Анхан шатны баримтаар нотлогдохгүй, худалдан авах гэрээ байгуулаагүй 2,830.1 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашиг хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 14.5. Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална, 20.1.4. хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд "нийцсэн болон зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 5.3 Албан шаардлага

Төсвөөс тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамаарахгүй 36,552.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

- Сургуулийн халуун усны засварт 6,000.0 мянган төгрөг
- Эрүүл мэндийн төвийн зуух шинэчлэх, суурилуулах зардалд 9,950.0 мянган төгрөг
- Багийн эмч нарт эмийн фонд нэмэгдүүлэх арга хэмжээний зардал 3,600.0 мянган төгрөг
- ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх зардалд 7,052.5 мянган төгрөг
- Хүүхдийн цэцэрлэгийн нам даралтын зуух солих, суурилуулах зардалд 9,950.0 мянган төгрөг

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 4.1.27. "орон нутгийн төсөв" гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг; 6.6.6. тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

#### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгатай холбоотой асуудал

**1.1. Илрүүлэлт:**

Санхүүгийн тайлангийн тодруулга тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн ирүүлээгүй бөгөөд аудитын хугацаанд нөхөж ирүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 "санхүүгийн тайлангийн тодруулга", Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4."хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан", 54.5.5."нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга", Сангийн сайдын 206 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар аргачлалтай тус тус нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгуудыг гаргаж санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж байх.

**2. Төсвийн зарцуулалттай холбоотой**

**2.1. Илрүүлэлт:**

Ном хэвлэлийн зардлаас 560,000.0 мянган төгрөг бичиг хэргийн материал худалдан авсан нь Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар баталсан Зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцэхгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

**3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой**

**3.1. Илрүүлэлт:**

Байгууллагын даргын гарын үсэг, тамгагүй 1,575.4 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн нь Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам-ын "7.5. Тухайн байгууллага бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтад заасан ТТ-1, ТТ-2 маягтын дагуу 2 хувь үйлдэн харьяалагдах төрийн санд хүргүүлнэ." гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн байгууллагын дотоод хяналтын зөвлөл нь төлөвлөгөөнд тусгагдсан 2 ажилд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.1-дэх заалттай нийцэхгүй байгаа ба үнэн ба зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн тохируулга хийгээгүй	1	45,803.4			1	45,803.4	1	45,803.4				
Дүн	1	45,803.4			1	45,803.4	1	45,803.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн зарцуулалттай холбоотой	1	3,580.1	1	3,580.1								
Төсвийн зарцуулалттай холбоотой	1				1	36,552.5						
Төсвийн зарцуулалттай холбоотой	1	560.1					1	560.0				
Тайланг иж бүрэн ирүүлээгүй	1	0					1	0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>4,140.2</b>	<b>1</b>	<b>3,580.1</b>	<b>1</b>	<b>36,552.5</b>	<b>2</b>	<b>560.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод хяналт хариуцлагатай холбоотой	1	1,575.4					1	1,575.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,575.4</b>					<b>1</b>	<b>1,575.4</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 20/АЭЭ-70648/ХДА-2023/138  
НД - СТА - ТШЗ

Мөрөн сум

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нохой устгалын ажил гүйцэтгэх гэрээнд сумны мөнгө 750,000.0 (долоон зуун тавийн мянга) төгрөгийг бүрэн хариуцахаар заасан боловч сумны мөнгийг давхардуулан олгосон байна.
2. Анхан шатны баримтаар нотлогдохгүй 2,830,100.0 (хоёр сая найман зуун гучин мянга нэг зуу) төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашиг хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 14.5.Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална, 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд "нийцсэн болон зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн

### ТОГТООХ нь:

1. Анхан шатны баримтгүй болон давхардуулан олгосон нийт 3,580,100 (гурван сая таван зуун наян мянга нэг зуу) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;


2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Цогт-Эрдэнэ, нягтлан бодогч Ц.Ундармаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:



А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

---

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 24 өдөр

№ 22/АЭДТӨБЧБ/ХАА-2023/183  
/НА-СТА-ТМБ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвөөс тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамаарахгүй 36,552.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Сургуулийн халуун усны засварт 6,000.0 төгрөг
- Эрүүл мэндийн төвийн зуух шинэчлэх, суурилуулах зардалд 9,950.0 мянган төгрөг
- Багийн эмч нарт эмийн фонд нэмэгдүүлэх арга хэмжээний зардал 3,600.0 мянган төгрөг
- Эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх зардалд 7,052.5 мянган төгрөг
- Хүүхдийн цэцэрлэгийн нам даралтын зуух солих, суурилуулах зардалд 9,950.0 мянган төгрөг

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.6.6.тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх; гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, төсвийг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж зарцуулах
2. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> нотлох баримтыг хамт ирүүлэхийг Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Цогт-Эрдэнэ, нягтлан бодогч Ц.Ундармаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Г.ИЧИНХОРЛОО

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043